



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот


Сургалт зохион байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9, 4 дүгээр хэсгийн 4.5.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Захирагчийн харьяа зарим байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон болон Захирагчийн ажлын албанаас харьяа газруудын дотоод ажилд явуулсан хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр харьяа газруудын захиргааны нэгжийн холбогдох албан тушаалтнуудад 2016 оны 4 дүгээр улиралд багтаан сургалт, арга зүйн ажил зохион байгуулахыг Үйл ажиллагааны мониторингийн хэлтэс /Ц.Рэгээдмаа/-т үүрэг болгосугай.

2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 287,500 /Хоёр зуун наян долоон мянга, таван зуу/ төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаад/-д, шаардлагатай зүйлсийг авч олгохыг нярав /Б.Халиун/-т тус тус зөвшөөрсүгэй.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т. ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 12 дугаар сарын 27
өдрийн 11.00 тушаалын 1 дүгээр хавсралт

ХАРЬЯА ГАЗРУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2016 оны 11 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

Зорилго: Улаанбаатар хотын Захирагчийн харьяа зарим байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон болон Захирагчийн ажлын албанаас харьяа газруудын дотоод ажилд явуулсан хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хийгдсэн дүн шинжилгээнийн мөрөөр харьяа газруудад ажлаа бүрэн, зөв төлөвлөх, тайлагнах, байгууллага, нэгжид дотоодын хяналтыг сайжруулах замаар дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг бүрэн, чанартай хангуулах асуудлаар нэгдсэн ойлголт өгч, хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлан таниулахад оршино.

Хамрах хүрээ:

Захирагчийн харьяа 10 байгууллагын Захиргааны хэлтсийн дарга, Дотоод хяналт хариуцсан албан тушаалтан, Хууль эрх зүйн мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд хамрагдана.

Зохион байгуулах хугацаа, байршил:

Хангарди ордны хурлын танхимд 2016 оны 12 дугаар сард багтаан явуулна.

Сургалтын агуулга, сэдэв.

НЭГ. УДИРДЛАГЫН НЭР ТӨРЛИЙН ЗАРИМ БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН АРГА ЗҮЙ.

09.⁰⁰-09.⁰⁵ Сургалтын нээлт /бүртгэл/.

09.⁰⁵-09.⁵⁰ Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар-баримт бичгийн стандартыг мөрдөх үйл ажиллагаанд анхаарах зарим асуудал.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаа

09.⁵⁰-10.⁴⁰ Төсвийн Ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагч нартай байгуулах үр дүнгийн 3 талт гэрээний болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, тайлагнах ажлын арга зүй, аргачлал.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

10.⁴⁰-11.³⁰ Контракт гэрээний төсөл боловсруулах, байгуулах, тайлагнах ажлын арга зүй, аргачлал

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн

11.³⁰-11.⁴⁰ Цайны завсарлага.

ХОЁР. БАЙГУУЛЛАГАД ДОТООД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН АРГА ЗҮЙ

11.⁴⁰-13.⁴⁰ Дотоод аудит, дотоод хяналтын ялгаа, түүний уялдаа,
Үндэсний Аудитын газрын Менежер
Ц.Батбаяр

13.⁴⁰-14.³⁰ Үдийн цайны завсарлага. /Сургалтад оролцогч өөрөө хариуцна/

14.³⁰-15.⁰⁰ Байгууллагад дотоодын хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрт
анхаарах зарим асуудал.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын
газрын
хэлтсийн мэргэжилтэн.


15.⁰⁰-15.³⁰ Захирагчийн ажлын албаны ҮАМХ-ээс 2016 онд харьяа газруудад явуулсан
хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд, тэдгээрийн хэрэгжилт үр дүн, анхаарах асуудал,
цаашдын хамтын ажиллагаа.

Улаанбаатар хотын Захирагчийн
ажлын албаны Үйл ажиллагааны
мониторингийн хэлтсийн Ахлах
мэргэжилтэн Б.Мөнхбаяр

15.³⁰-15.⁴⁰ Сургалтыг дүгнэж хаах.

Улаанбаатар хотын Захирагчийн
ажлын албаны Үйл ажиллагааны
мониторингийн хэлтсийн дарга
Ц.Рэгзэдмаа

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 11 дугаар сарын 07 нд
өдрийн А/160 тушаалын 2-р хавсралт



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

2016 оны 11 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
Багшийн хөлс					
1	Багшийн цалин хөлс	цаг	3	50 000	150,000
2	Печень	хайрцаг	15	3500	52,500
3	Кофе, цай	уут	5	7000	35,000
4	Цэвэр ус	ш	100	350	35,000
5	Салфетка, нэг удаагийн цайны хэрэгсэл				15,000
Нийт дүн					287,500